



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
БИЕЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар A/45

Улаанбаатар хот

□ Байгууллагын дотоод журамд нэмэлт, □  
өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоол, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар бүлгийн 8.1.3, 8.1.4-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын даргын 2022 оны A/06 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулж хавсралтаар баталсугай.

2.Хөдөлмөрийн дотоод журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн мөрдөж, Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллахыг Нэгжийн дарга нар, нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНСҮРЭН



Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2023 оны 07-дугаар сарын 03-ны өдрийн А/45 тушаалын хавсралт



**БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД  
ЖУРАМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

1.Байгууллагын даргын 2022 оны А/06 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журамд дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай. Үүнд:

1.1.Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын "Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн бололцоог харгалзан ажилтанд тэдгээрийн мэргэжил, мэргэшлийн үр чадвар, ажлын чанар үр дүн, мэргэжлийн зэрэг, хөдөлмөрийн нөхцөл зэргийг харгалзан зохих хууль, журмыг үндэслэн байгууллагын даргын тушаалаар батлагдсан журмын дагуу үндсэн цалин, нэмэгдэл хөлсийг тогтоон олгоно" гэснийг "Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн бололцоог харгалзан ажилтанд тэдгээрийн мэргэжил, мэргэшлийн үр чадвар, ажлын чанар үр дүн, мэргэжлийн зэрэг, хөдөлмөрийн нөхцөл зэргийг харгалзан зохих хууль, журмыг үндэслэн байгууллагын даргын тушаалаар батлагдсан журмын дагуу үндсэн цалин, хоолны нэмэгдлийг 9,000 төгрөг, унааны нэмэгдлийг 2,000 төгрөгөөр тогтоон олгоно" гэж нэмэх.

1.2.Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын "Ажилтан нь үндсэн ажлынхаа зэрэгцээгээр хавсран ажиллах гэрээний дагуу ажил гүйцэтгэсэн бол ажлын ачаалал, үр дүнг харгалзан дундаж цалин хөлсийг 40% хүртэл хувиар нэмэгдэл хөлс олгоно" гэснийг "Ажилтан нь үндсэн ажлынхаа зэрэгцээгээр хавсран ажиллах гэрээний дагуу ажил гүйцэтгэсэн бол ажлын ачаалал, үр дүнг харгалзан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах болон Хөдөлмөрийн гэрээ байгуулж, түүний биелэлт, үр дүнг улирал тутам холбогдох журмын дагуу тайлагнаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, гэрээний гүйцэтгэл, үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож дундаж цалин хөлсийг 40% хүртэл хувиар нэмэгдэл хөлс олгоно" гэж өөрчлөх,

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_